



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ

2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд тус парк 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд:

- Монгол улсын Засгийн газрын тогтоол – 2
- Нийслэлийн Засаг даргын захирамж – 6
- Төрийн болон бусад байгууллагаас нийт 218 албан бичиг ирснээс хариутай албан бичиг нь 67 байж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагаас бусад байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 245 албан бичиг явуулсан.

**НЭГ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО: 3.2
ХОТЫГ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН ТӨВ БОЛГОН ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

1.1. Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг үргэлжлүүлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

- 2023 оны Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг объектын барилга угсралтын ажилд 500,000,000 төгрөг төсөвлөгдөн шийдвэрлэгдсэн ба 2023 оны хагас жилийн Нийслэлийн төсвийн тодотголоор нийслэлээс бонд гаргаж, он дамнан хэрэгжиж буй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр шийдвэрлэж уг жагсаалтад паркийн 110 кВ-ын ЦДАШ, 2х16 мВА чадалтай 110/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын “Налайх” дэд станцын Ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгах ажил багтсан боловч, бонд гаргах асуудал зогссон болно. 2023 оны 10 дугаар сард Нийслэлийн төсвийн тодотгол хийснээр уг объектын шинэчилсэн төсвийг 16,200,000,000 төгрөгөөр, энэ ондоо 7,000,000,000 төгрөг батлуулсан. Үлдэгдэл санхүүжилт 6,208,000,000 төгрөгийг нийслэлийн 2024 оны төсөвт батлуулсан. Дээрх төсөл арга хэмжээ 2024 онд бүрэн дуусаж ашиглалтад хүлээж авна.

1.2. Паркийн дулааны станц, бусад дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.

- Эрчим хүчний яамнаас 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулахаар баримт бичгийг бэлтгэн хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Иймд 2024 оны улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар баримт бичгийг бэлтгэн хүргүүлсэн болно. 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Дэлхийн банкны төслийн багийн ахлагч ахлах мэргэжилтэн Гёншим Ан, тэргүүлэх эдийн засагч Винсент Палмад нартай уулзалт хийн паркийн танилцуулга мэдээлэл, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулсан.

**ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН
ЗОРИЛГО: 6.2. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТой
НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ УЯЛДУУЛЖ, ХҮН АМЫН
НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ БҮС, ОРОН
НУТГИЙН ХӨГЖЛИЙН УЯЛДААГ ХАНГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

2.1. БМБХТөвийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.

- Барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд танилцуулга мэдээлэл хийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүсэлт гаргасан. Зураг төсвийн хөрөнгө оруулалтын асуудал Эдийн засгийн Хөгжлийн яаманд шилжсэн тул тус яаманд хүсэлт гаргасан шийдвэрлэгдээгүй. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв”-ийн иж бүрэн зураг төсвийг хийлгэхээр “Улаанбаатар групп” ХХК- тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

**ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН
ЗОРИЛГО: 4.1. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН УХААЛАГ ШИЙДЛҮҮДИЙГ АШИГЛАН**

ХОТЫН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ, НЭЭЛТТЭЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ ХҮРГЭДЭГ УХААЛАГ ХОТЫГ БИЙ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

3.1. Арга хэмжээ 1: 4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

- Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын хүрээнд байгууллагаас гаргасан албан тушаал, шийдвэр, гэрээ хэлцэл, төсөв хөрөнгө захиран зарцуулах болон байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, санхүүгийн тайлан мэдээ, орлого, зарлага, санхүүжилт, өндөр дүнтэй гүйлгээ зэрэг бүх мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан. Шилэн дансанд мэдээлэх 17 төрлийн 137 мэдээг хуулийн хугацаанд бүрэн хүргүүлж ажилласан.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

4.1. 110/10 кВ-ын 2х16 мВА чадалтай дэд станцын угсралтын ажлыг бүрэн дуусгах ажилд хяналт тавих.

- Нийслэлийн төсөвт тусгагдсан 7,500,000,000 төгрөгийн эх үүсвэрт багтаан үндсэн цахилгаан хангамжийг үргэлжлүүлэн, гүйцэтгэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна. Үлдэгдэл санхүүжилт болох 6,208,000,000 төгрөгийг Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөгдөж батлагдсан.

4.2. Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах.

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 16 аж ахуйн нэгж паркт байрших хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн төсөл, байгаль орчинд ээлтэй, хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, шинэ технологийн талаарх мэдээллийг судалж дүгнэлтийг гарган 14 аж ахуйн нэгжтэй шинээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2023 онд 5-н үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн ба “Экоминерал трейд” ХХК, “Сайхан улаан оргил” ХХК, “Төгсбридж” ХХК, “Электрокем монголиа” ХХК, “Нью метод” ХХК гэсэн 5-н аж ахуйн нэгж үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлээд байна.

4.3. Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, хяналт үнэлгээ хийнэ.

- Паркийн 250 га газар дээр нийт 52 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 24 аж ахуйн нэгжтэй гэрээ дүгнэн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бичиг баримт, зураг төслийн бүрдлийг хангах шаардлага хүргүүлсэн. 9 үйлдвэрийн үйл ажилгаа явуулах гэрээ цуцалсан. 10 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 5 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн барилга угсралтын ажил 80%-тай явагдаж байна. 5 аж ахуйн нэгжид үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай цахилгаан хангамжийн түр тэжээлээр хангаад байна.

4.4. Паркийн цэвэр ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж, УДДТ-үүдийн барилга байгууламжийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийг хийлгэх хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох газруудаар шийдвэрлүүлэх.

- Барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд танилцуулга мэдээлэл хийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүсэлт гаргасан. Зураг төсвийн хөрөнгө оруулалтын асуудал Эдийн засгийн Хөгжлийн яаманд шилжсэн тул тус яаманд хүсэлт гаргасан шийдвэрлэгдээгүй. 2024 оны Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн.

- 4.5. Паркийн 250га талбайд техник технологийн төвшний ерөнхий үнэлгээ хийлгэх.
- Барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд танилцуулга мэдээлэл хийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүсэлт гаргасан. Зураг төсвийн хөрөнгө оруулалтын асуудал Эдийн засгийн Хөгжлийн яаманд шилжсэн тул тус яаманд хүсэлт гаргасан шийдвэрлэгдээгүй.
- 4.6. Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах ажлыг зохион байгуулах.
- Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор өмчлөлийн хэлбэр өөрчлөгдсөний дараа тусгай зөвшөөрөл сунгуулж шинээр авах ажлыг зохион байгуулна. Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримтын бүрдлийг хангасан.
- 4.7. Паркийн 250 га талбайн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлүүлэх.
- Барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд танилцуулга мэдээлэл хийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүсэлт гаргасан. Зураг төсвийн хөрөнгө оруулалтын асуудал Эдийн засгийн Хөгжлийн яаманд шилжсэн тул тус яаманд хүсэлт гаргасан шийдвэрлэгдээгүй.
- 4.8. Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэвийн тасралтгүй явуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж өглөг авлагагүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- Санхүүгийн тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бүртгэж хөтлөх, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бодитой тайлагнаж байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж нөхцөлөөр ханган анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг бэлтгэн ажиллаж байна. Нийслэлийн төсвөөс 389,889,9 төгрөгийг санхүүжилтийг бүрэн авсан. Жилийн эцсийн байдлаар өр авлага үүсээгүй төсийн мэдээг хуулийн хугацаанд бүрэн тайлагнан ажиллаж байна.
- 4.9. Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын сайт, цахим хуудсандаа үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол тавьж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа хийх.
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:
 - Үйл ажиллагааны ил тод байдал,
 - Хүний нөөцийн ил тод байдал,
 - Төсөв, санхүүгийн ил тод байдал,
 - Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна.
- 4.10. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.
- Гадаад томилот – 3
 - Зочид төлөөлөгчид – 6
 - Албан уулзалт – 4
 - Сургалт, семинар – 3 тус бүр нэг хийгдэж, тухай бүрт нь байгууллагын үйл ажиллагааны болон, шаардлагатай хөрөнгө оруулалт, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллийг танилцуулж, хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж ажилласан.
 - БНХАУ, БНСУ, ХБНГУлсуудын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчидтэй түлхүү холбогдож ажиллалаа.

- 2023.03.31-нд НБМҮТ Паркад БНСУ-ын KSP компанийн гүйцэтгэх захирал Dr. Taihee Lee, төслийн мэргэжилтэн Keun-Young Yoon, KISME компанийн ерөнхий захирал Dr. Do-Sung Na, нарийн бичиг Pf. Young-Ho Youn, гүйцэтгэх захирал Dr. Chong-In Lim, гүйцэтгэх захирал Dr. Jang-Ho Choi, KICOX компанийн судлаач Dr. Jong-Tae Choi болон УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын шинжээч Ц.Оюунболд нар ирж, Паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авч, Паркт байршсан Пийс стийл групп ХХК, Эко минерал ХХК нарын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцлаа. Газрын дарга С.Батжаргал үйл ажиллагааны мэдээлэл өгч, Ерөнхий инженер Б.Батбилэг, Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэн, Цахилгааны инженер Б.Гансүх нар тус тусын чиглэлээр мэдээлэл өгөв. Мөн Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Газрын дарга Ч.Элбэгсайхан хүрэлцэн ирж, Багануурын паркийн үйл ажиллагаа, цаашдын төлөвлөгөөний талаар мэдээлэл өглөө. KSP компанийн гүйцэтгэх захирал Dr. Taihee Lee БНСУ-ын үйлдвэрлэл, технологийн паркуудийн засаглал, үйл ажиллагааны талаар танилцуулж, туршлага солилцсон. Цаашдаа Паркийн хэтийн төлөв, хөгжлийн бодлого, засаглалын талаар зөвлөгөө өгч, хамтран ажиллахаар боллоо.



- 2023 оны 04 сарын 11-13-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод байрлах “V World Korea” ХХК-ын дулааны станцтай танилцаж дулааны станцын хүчин чадал, үйлдвэрийн горим, технологийн талаар туршлага солилцов. БНСУ-ын томоохон үйлдвэрлэгч байгууллагуудын үйлдвэрлэл, шинэ дэвшилтэт техник технологитой танилцаж, туршлага судлах, үйлдвэрлэлийн процессыг газар дээр нь үзэх, паркад нутагшуулж болохуйц үйлдвэрлэлийг татан оруулж ирэх зорилгоор “V World Korea” ХХК нь Газын хоолойн үйлдвэрлэл, барилгын технологид тулгуурлан Монгол орны агаарын орчныг сайжруулахын тулд хамгийн шилдэг технологи, туршлагаар газын хоолойн төсөл боловсруулсан. 4 сарын 12-ны өдөр очиж танилцсан дулааны станц нь хог хаягдлыг дахин боловсруулж, газ, дулаан болон эрчим хүч гарган авах технологи бүхий, 10МВ-ын хүчин чадалтай шинэ дэвшилтэт станц юм. Уг компани нь Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парктай хамтран, Паркийн 120 га талбай дахь 40-50 үйлдвэрийг бүрэн хангах дулааны станц барих төлөвлөгөөтэй ажиллаж байна.



- 2023 оны 04 сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2023” чуулга уулзалтад НБМҮТП амжилттай оролцлоо. Уг чуулга уулзалтаар 400 орчим гадаад дотоодын хөрөнгө оруулагчидад төслөө танилцуулж, илтгэл тавин, мэдээлэл хүргэж ажиллалаа.



- 2023-05-10 БНГУ –ын Вуппертал Институтээс анхны экспертүүдийн онлайн хэлэлцүүлэг зохион байгуулав. Уг хэлэлцүүлгээр хөгжиж буй орнуудын эрчим хүч сэргээгдэх эрчим хүчрүү шилжих нийгэм эдийн засгийн үр нөлөө, бумад улсуудын сайн жишиг ирээдүйд тулгарч болох бэрхшээлүүдийн талаар санал болилцов. уулзалт болов. Энэхүү уулзалтанд Ази европ, өмнөд америк тивийн 8 улсад хэрэгжиж байгаа бөгөөд эрчим хүчний системээс утаагүй цэвэр, уур амьсгалд тэсвэртэй эрчим хүчний системд шилжих шилжилтийг хурдасгах нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангахад томоохон хувь нэмэр оруулах зорилготой юм. Энэхүү цахим хуралд Монгол улс тэр дундаа НБМҮТПаркийг төлөөлөн өөрийн улс орны өнөөгийн байдлын талаар танилцуулга хийн туршлага судлан оролцов.

- 2023-05-18-ны өдөр НБМҮТПаркийн албан хаагчид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Городок явах зам дагуу 135 ширхэг улиас, хайлаас мод тарилав. Энэ жил төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотой 11 байршилд 4.7 сая мод тарьж, ургуулахаар төлөвлөсөн. Дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн албанаас усалгаа, хар шороо зэргийг хариуцан бэлдсэн байлаа.



- 2023 оны 05 сарын 22-ны өдөр Парктай хамтран ажиллах хүсэлт гаргаад байгаа БНХАУ-ын Ивтекс ХХК нь НБМҮТПаркийн үйл ажиллагаатай танилцахаар ирлээ. Тус үйлдвэр нь хаягдал дугуй жижиглэн, дахин боловсруулж, резин хавтан үйлдвэрлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх

нөлөө хамгийн бага байхаар БНХАУ-аас туршлага судлаж байгаа юм. Уг үйлдвэр нь ашиглалтад орвол 10кВ-ын цахилгаан эрчим хүч, жилд 2000тн ус зарцуулах төлөвлөлттэй бөгөөд саарал усаа дахин ашиглах технологитой юм. Мөн тус үйлдвэр нь дэргэдээ цэвэрлэх байгууламж барихаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад нэн шаардлагатай байгаа цэвэрлэх байгууламжийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой болох тухай дурьдлаа. Хаягдал дугуй дахин боловсруулах үйлдвэрийг барихад Паркийн зүгээс нэн тэргүүний тулгамдаж байгаа зүйл нь үндсэн цахилгаан хангамжийн асуудал бөгөөд одоогийн байдлаар 110/10кВ-ын цахилгаан станцын бүтээн байгуулалт 30 хувьтай явагдаж байна.



2023-05-23-нд Налайх парк нь 120 га талбайд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийг усаар хангах 8,96л/сек ундрага бүхий 2 худгаас гадна “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн ажил гол болон салбар шугамын шуудууны буцаан булалтыг механизмаар тэгшлэх, усан сан насос станцын барилгын гадна цахилгаан, автоматжуулалтын ажил, үзлэгийн худгууд дотор хаалт арматурын бетон зутгах, ум дамжуулах салбар шугамын даралт шалгах тестийн ажил, гүний худгууд насос станцын автоматжуулалтын ажил зэрэг ажлууд хийгдэж дууссан. 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн үйлдвэрийн ус хангамжийн барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх техникийн улсын комисс ажиллав.



- 2023-05-26-нд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн санаачилгаар Аж үйлдвэржилтийн үндэсний зөвлөгөөнийг өнөөдөр зохион байгууллаа. Зөвлөгөөний гол зорилго нь салбарын хөрөнгө оруулалт, эрх зүйн орчин, аж үйлдвэржилтийн сэргэлтэд чухал үүрэгтэй эрчим хүч,

дэд бүтцийн нөөц боломж, төр, хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулах зэрэг өргөн хүрээнд тодорхой шийдэл гаргахад чиглэж буй. Аж үйлдвэржилтийн Үндэсний хороо, УУХҮЯ, Уул уурхайн үндэсний ассоциац, “Эрдэнэс Монгол” нэгдлээс хамтран зохион байгуулж буй тус зөвлөгөөнд дотоод, гадаадын 1000 орчим төлөөлөгч оролцов. “Аж үйлдвэржилтийн сэргэлт”-ийг эрчимжүүлэхэд Засгийн газар одоо онцгой анхаарна гэдгээ энэ үеэр Ерөнхий сайд албан ёсоор зарлав. Түүхий эдийн экспорт давамгайлсан манай улсын хувьд экспортын үндсэн түүхий эд болох нүүрс, газрын тос, зэс, төмрийн хүдрийн боловсруулах үйлдвэр байгуулж, дэвшилтэт технологи, инновацад суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нэн тэргүүний зорилт тавигдаж байгаа юм. Уг зөвлөгөөнд байгууллагын удирдлага болон хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн оролцоллоо.



- 2023 оны 06 сарын 02-07-ны өдрүүдэд МУУХҮЯ-ны албаны хүмүүс болон паркийн удирдалга, БНСУ-ын хөгжлийн хүрээлэн, БНСУ-ын жижиг дунд үйлдвэрийн институт, БНСУ-ын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх уул уурхайн нөхөн сэргээлт, эрдэс баялагийн корпорацууд хамтран хөрөнгө оруулагчдын чуулга, уулзалтыг БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулав. Тус хуралд 2 орны засгийн газрын сайд, төлөөлөгчид, 22 олон улсын байгууллага, БНСУ-ын 45 хөрөнгө оруулагч компаниуд оролцон Монгол улсад үйлдвэрлэл технологийн паркуудын стратеги, эдийн засгийн хөгжлийг дэмжих, туршлага солилцох, бодлогын зорилтууд гаргав. Уулзалтын үеэр хоёр орны хууль, эрх зүйн тогтолцооны талаар туршлага хуваалцаж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцон хөрөнгө оруулагч байгууллагуудтай холбоо тогтоов.



- 2023.06.13-ний өдөр Налайх дүүргийн_Засаг даргын Тамгын газар, Германы хамтын ажиллагааны байгууллага хамтран Европын холбооны санхүүжилттэй "Эрчим хүчний зохистой шилжилт" төслийг танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад "Налайхын дулааны Станц" ТӨХК, "УБЦТС" ХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төв, "УБЦТС" ХК-ийн Түгээх төв, Таван толгой түлш ХХК, Налайхын Барилгын материал, үйлдвэрлэл, технологийн парк, Эрчим хүчний үндэсний төв зэрэг байгууллагуудын удирдлагууд, инженерүүд, уурхайчдын төлөөлөл, дүүргийн удирдлагууд, "IKI JET" төслийн ахлах мэргэжилтэн Ларс Блюм, төслийн зөвлөх С.Цэрэндаш нар оролцлоо. Талууд уулзалтын үеэр "IKI JET" төслийн талаар ойголтыг авч, нүүрсний эрчим хүчнээс сэргээдэх эрчим хүчид шилжих төслийг дүүрэгт хэрэгжүүлэх талаар санал солилцсон юм.
- 2023-06-19 БНСУ-ын жижиг дунд үйлдвэрүүдийн холбооны тэргүүн болон Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны хамт олон НБМУТПаркийн үйл ажиллагаатай танилцахаар ирсэн бөгөөд энэхүү уулзалтаар Монгол улсад хөрөнгө оруулах сонирхолтой



БНСУ-ын жижиг дунд үйлдвэрүүдийг холбогдох, хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор паркийн мэдээллийг БНСУ болон БНХАУ-ын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд түгээх зорилгоор танилцуулга мэдээллийг англи, солонгос, хятад хэл дээр бэлтгэн өгөв. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдын хууль эрх зүйн орчин, тэр дундаа Налайхын парсад үйл ажиллагаа явуулснаар хуулийн ямар боломжит хөнгөлөлтүүд байгаа талаар уулзаж мэдээлэл солилцов.



- 2023-06-23-ны өдөр Монголын анхдагч чулуун хийцийн үйлдвэр болох Ногоон цагираг ХХК-ны “Байгалийн чулуу Боловсруулах 1-р үйлдвэр”-ийн үйлдвэр танилцуулах нээлттэй өдөрлөг боллоо. Тус компани нь Монголдоо 100 хувь байгалийн түүхий эд болох чулууг боловсруулж, олон төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд импортоос хямд үнээр нийлүүлж байгаа бөгөөд дотоодын зах зээлд баялаг бүтээн, импортыг орлож шат дараатай ашиглалтанд оруулж, хүчин чадлаа нэмэгдүүлснээр байгаа юм. Тус өдөрлөгт Паркийн удирдлага болон мэргэжилтнүүд үйлдвэртэй биечлэн танилцлаа.



- 2023.06.26-нд БНСУ-ын Лузерн Эм Кэй ХХК-ын удирдлагууд парк дээр ирж уулзалт хийлээ. Уулзалтаар гэрээний биелэлт, тайлан болон цаашид үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах цахилгааны асуудлыг судлаж, санал солилцлоо.
- 2023 оны 07 сарын 04-ны өдөр Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан Улаанбаатар групп ХХК-ийн ТУЗ-ын дарга Ц.Батбаатар, Ажлын албаны дарга н.Түвшинтөр болон БНХАУ-ын Шандун мужийн Юн Лян группын захирал Лю нар НБМҮТПаркад ирж, Паркийн үйл ажиллагаатай танилцлаа.
- Юн Лян групп нь БНХАУ-ын цементийн томоохон үйлдвэрүүдийн нэг бөгөөд цемент, блок, шил, шилэн эдлэлийн үйлдвэрлэл, тээвэр зууч, гадаад харилцаа зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байгаа юм. Энэ удаад Улаанбаатар групп ХХК-тай хамтран Паркийн нутаг дэвсгэрт бүх төрлийн бетон хийц, эдлэлийн үйлдвэр барихаар төлөвлөж байна.Тус группын зүгээс үйл ажиллагаагаа эхлүүлэхэд шаардлагатай байгаа Паркийн үндсэн цахилгаан хангамж болон дулааны станцын ажлын явцыг сонирхон, мэдээлэл авлаа.Мөн Паркийн Барилгын Материалын Бөөний болон Жижиглэнгийн Худалдааны Төв байгуулахаар төлөвлөж буй 60 га газрын төлөвлөлт, цаашдын үйл ажиллагаатай танилцсан.



- 2023 оны 08 сарын 08-ны өдөр БНСУ-ын Жэжүгийн Үндэсний Их Сургуулийн дэргэдэх SW Convergence боловсролын төвийн WFK Мэдээллийн технологийн сайн дурын баг НБМҮТПаркад ажиллалаа. Тус баг нь 2023 оны 07 сарын 21-нээс нэг сарын хугацаатайгаар Монголд ажиллаж байгаа бөгөөд Монголын мэдээллийн технологийн хөгжлийг дэмжих, түгээн дэлгэрүүлэх үндсэн зорилготой юм. НБМҮТПаркад SW Convergence боловсролын төвийн дарга, профессор Cho Jin Youl, профессор Byun Tae Bo нар болон бусад сайн дурын ажилтнууд ажиллаж, Паркийн мэдээллийн технологийн хөгжүүлэлтэд томоохон хувь нэмэр орууллаа. Уг төсөл нь Жэжүгийн Үндэсний Их Сургуулийн SW Convergence боловсролын төв болон Солонгосын оюуны чадамжийн агентлагтай хамтран 24 сайн дурын оюутнуудыг Монгол, Танзани, Индонези гэсэн 3 оронд ажиллуулж, туршлага солилцож байгаа юм байна.



- 2023 оны 08 сарын 15-ны өдөр БНСУ-ын "eVLink" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Park Gyong Chol, "Shinan" Co,ltd компанийн Шинэ бизнес хариуцсан захирал Kim Jae Nak нар болон Канад Улсын хаягдал тос дахин боловсруулах "Little dipper holdings" LTD компанийн үүсгэн байгуулагч, ЭБЭГ ХХК-ийн зөвлөх Лес Харпер, Гадаад, дотоод худалдаа, үйлдвэрлэл, газар тариалан, нөхөн сэргээлтийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ЭБЭГ ХХК-ийн удирдлагууд, захирал А.Энхбаатар, Монголын Хог Хаягдал дахин боловсруулах үндэсний холбооны тэргүүн Д.Батжаргал нар Налайх Паркад зочилж, Паркийн үндсэн үйл ажиллагаа, дэд бүтцийн явц болон ашиглалтад орсон үйлдвэрүүдийн мэдээлэлтэй танилцлаа. Уулзалтад Паркийн дарга С.Батжаргал, Инженер Б.Батбилэг, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Чимэгжаргал нар оролцож, Паркийн ерөнхий мэдээллийг өгч, сонирхсон асуултад хариулсан. Цаашид Парктай хамтран ажиллах гэрээ байгуулж, хаягдал дахин боловсруулах, нөхөн сэргээлтийн чиглэлийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг судлаж байна.

- 2023 оны 10 сарын 18-ны өдөр Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан "Улаанбаатар групп" ХХК-ын төлөөлөгчид БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын хамтаар хүрэлцэн ирж, Паркийн үйл ажиллагаа, дэд бүтцийн ажлын явцын талаар мэдээллийг хөрөнгө оруулагч талдаа танилцууллаа. Хөрөнгө оруулагч "Zhong Yi" ХХК нь 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд барилгын зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхлэсэн ба одоогийн байдлаар хүнд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэж ОХУ, Казакстан, Камбож, Пакистан зэрэг орнуудад нийлүүлдэг БНХАУ-ын томоохон үйлдвэрлэгч юм. Тус компанийн Хөгжүүлэлтийн хэлтсийн захирал Wu Xiaofei тэргүүтэй мэргэжилтнүүд Паркт ирж, Паркийн цахилгаан станцын хүчин чадал, дулааны станцын ашиглалтад орох хугацаа зэргийг тодруулан, мэдээлэл авлаа.



• 2023 оны 11 сарын 09-ны өдөр БНСУ-ын хөрөнгө оруулагчид ирж Паркийн үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл солилцлоо. Centum Live Work ХХК-ийн Гүйцэтгэх захирал Kim Chang Ho, Hwan архитектурийн фирмийн Захирал Lee Gi Man, Архитектор Ban Cheol Hwan, Jusung ХХК-ийн Архитектор Lee Joo Yong, Hanjingeo иргэний инженерингийн компанийн Гүйцэтгэх захирал Kim Yong Hak болон Daehan construction ХХК-ийн Jang Seok Won, Cheong Yong Jin тэргүүтэй хөрөнгө оруулагчид айлчилж, Паркт хийгдсэн бүтээн байгуулалт болон үйлдвэрүүдийн мэдээлэлтэй танилцсан бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан хөнгөлөлт, давуу тал байгаа эсэх талаар сонирхож, Үйлдвэрлэл технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан. БНСУ-ын томоохон барилгын компани болох DAEHAN констракшн нь дэлхийн хэмжээний компани болтлоо өргөжин хөгжиж, үсрэнгүй хөгжлийн замаар брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зорьж байгаа бөгөөд,

- Барилгын тоног төхөөрөмжийн гүйцэтгэгч ,
- Барилгын өнгөлгөөний гүйцэтгэгч ,
- Суурь, бүтэц, барилгын гадна талын гүйцэтгэгч ,
- Хурдны зам, гудамж, гүүрийн барилгын ажил ,
- Орон сууцны бус барилгын барилга ,
- Хүнд болон барилгын бусад барилга угсралт ,
- Бусад мэргэшсэн худалдааны гүйцэтгэгч ,
- Орон сууцны барилга зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч компани юм.



- 2023 оны 12 сарын 01-ны өдөр Ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх, сургалтын үйл ажиллагаанд хамтын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Түншлэл-2023” уулзалтыг Налайх дүүрэг дэх Политехник коллежоос зохион байгуулсан. Уулзалтад үндэсний болон бүс нутаг, салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 24 байгууллагын төлөөлөгч, тус коллежийн мэргэжлийн багш нар мөн эцэг эх, суралцагчийн төлөөлөл оролцож санал солилцсон.



4.11. Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй, албан бичгийн норм стандартыг мөрдөх, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

- Эдок системд 2023 оны жилийн эцсийн байдлаар 218 бичгийг хяналтад авч хугацаанд нь шийдвэрлэн зөрчилгүй ажилласан. Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж индекс 0,4447 байна.
- ННЗБ-ын Эдок системийг албан бичиг солилцооны дундын систем (DOCX)-тэй холбогдож бусад төрийн байгууллагуудтай цахимаар албан бичиг илгээх, хүлээн авах болсонтой холбогдуулан гэрээ байгуулан холболтыг хийлгэсэн.
- Хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтын мэдээг улирал тутам тайлагнаж, үргүй зарцуулсан хэвлэмэл хуудсыг хагас, бүтэн жилээр даргын тушаалаар хүчингүй болгож байна.

4.12. Иргэд, албан хаагчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээ тайланг НЗДТГ-т хүргүүлэх.

Албан хаагчдаас нийт 15, иргэнээс 1 өргөдөл ирсэн бөгөөд системд бүртгэн хариуцсан албан тушаалтнуудад шилжүүлэн шаардлагатай тушаалыг боловсруулан холбогдох удирдлагуудаар хянуулж, даргаар батлуулан шийдвэрлэлтийг хуулийн дагуу, хугацаанд нь шийдвэрлэж байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног 1 өдөр байна.

Өргөдөл гомдлын тайлан мэдээг улирал бүрийн сүүлийн 7 хоногт НЗДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлдэг бөгөөд 3 улирлын тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

4.13. Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивд бүрдүүлэлт хийх.

- Байгууллагын архивын төлөвлөгөө, архивд баримт хүлээн авах хуваарь, 2023 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлан хуваарийн дагуу албан хаагчдаас цаасан болон тусгай төрлийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэлийг шинэчлэн үйлдсэн. Архивын өрөөний чийгшил, цэвэрлэгээ үйлчилгээ, түр олгосон баримтын бүртгэл, хуулбар олгосон баримтын бүртгэл зэрэг шаардлагатай бүх бүртгэлийг тухай бүр нь хөтөлж байна. Мөн газрын даргын 2022 оны захирамжлалын цахим баримтыг архивын дэд системд бүртгэн нийслэлийн Архивын газарт цахим тээгчид

буулган хүлээлгэн өгсөн. 2023 онд төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу бэлтгэл байдлыг ханган ажиллаж МА33-ын хурлаар данс бүртгэлээ хэлэлцүүлсэн.

4.14. Албан хаагчдыг чадавхижуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтад хамруулах.

Дүүрэг, нийслэл болон холбогдох газруудаас зохион байгуулсан 16 сургалтад давхардсан тоогоор 41 албан хаагчийг хамруулсан

- АТГ-ХАСХОМ мэдүүлэгчдэд заавар, зөвлөмж олгох сургалт – 2
- НЗДТГ- Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй, төлөвлөлт, гүйцэтгэлд, тайлагналт, хяналт үнэлгээний сургалт – 2
- НД-ийн Татварын алба – 1
- НАГ- Төрийн архивд нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагуудад чиглэл олгох сургалт – 1
- НЗДТГ- Төрийн сангийн төлбөр тооцооны цахим систем нэвтрүүлэлт – 1
- НЗДТГ-ын “Төрөөс стандартчилал, хэмжилзүйн талаар баримтлах бодлого”, “Стандарт ба хөгжил” хөтөлбөрийн хэлэлцүүлэг – 3
- НЗДТГ- стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй – 2
- НДЗДТГ– Амьдралын эрүүл дадал зуршил, харилцаа хандлага сургалт – 8
- НЗДТГ– Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх сургалт -1
- НЗДТГ – Хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлангийн дэд системийн сургалт – 2
- НЗДТГ, ЖАЙКА – Эдийн засаг, санхүүгийн шинжилгээний арга зүй – 1
- НЗДТГ, ЖАЙКА – Төслийн боловсруулалт, эх үүсвэрийн төрөл – 1
- НДЗДТГ – Татварын хуулийн сургалт – 2
- НЗДТГ – Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар танилцуулга, сургалт – 1
- НЗДТГ – Төрийн албан хаагчийн цалингийн программын хөгжүүлэлт – 1
- НД-ийн Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтсээс “Нэгдүгээрт хүүхэд” аяны хүрээнд зохион байгуулсан сургалт – 9 албан хаагч тус тус оролцсон.

Байгууллагын дотоод сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 25 албан хаагч хамрагдсан.

Дээрх сургалтуудад нийт давхардсан тоогоор 66 албан хаагч хамрагдсан.

4.15. Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар сурталчлах, албан хаагчдад мэдээлэл өгөх, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.

- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын нийт ажиллагсдын хүйсийн тэнцвэрт харьцааг ханган, жендэрээр ялгаварлан гадуурхах эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтны хөдөлмөрийн харилцааг дуусгахгүй байх заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.16. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO 45001:2018 стандартыг мөрдүүлж ажиллах.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төлөвлөгөө гарган нийт албан хаагчдад даргын 2020 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан оффисын ажилтны ХАБЭА-н зааварчилгаа, үйлчилгээний ажилтны ХАБЭА-н зааварчилгааг мөрдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2023 оны жилийн эцсийн байдлаар)

№	ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ**	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.												
11	3.7.11.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.	8.Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна	2020-2023	НЗДТГ	Улсын төсөв, Нийслэлийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт		НБМҮТП-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан, 120 га талбайд үйлдвэрийн барилга байгууламжийг барих ажлыг эхлүүлсэн.		Инженерийн дэд бүтцийг барих ажлыг үргэлжлүүлнэ.		Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолд ЗГҮАХ-ийн 3.7.11.8 дахь арга хэмжээний 2023 оны хүрэх түвшинг “Инженерийн дэд бүтцийг барих ажлыг үргэлжлүүлнэ.” гэж төлөвлөсөн. - Паркийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 2x16 мВА чадалтай дэд станц, 10 кВ-ын 4 ширхэг хуваарилах байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын үлдэгдэл ажлыг 7,500,0 сая төгрөгийн эх үүсвэрт багтаан үндсэн цахилгаан хангамжийг үргэлжлүүлэн гүйцэтгэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна. - Мөн үлдэгдэл ажлын санхүүжилт болох 6,208,000,000 (зурган тэрбум хоёр зуун найман сая) төгрөгийг Нийслэлийн 2024 оны төсөвт батлуулсан.	87
41		2. "Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн		2021-2024	НЗДТГ				Дэд бүтцийн бүтээн байгуулалт, хувь - 20		Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолд ЗГҮАХ-ийн 6.1.11.2 дахь арга хэмжээний 2023 оны хүрэх түвшинг “Дэд бүтцийн бүтээн байгуулалт, хувь-20” гэж төлөвлөсөн.	30

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4 дүгээр хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	5	19	НЗДТГ-11, НАГ -1, АТГ - 1 НДЗДТГ-3, дотоод сургалт-3 сургалтад давхардсан тоогоор байгууллагын 66 албан хаагчийг сургалтад хамруулав
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	3	
			Мэргэшүүлэх сургалт	-	-	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	16	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	66	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	45	
			Эрэгтэй албан хаагч	-	21	
			Удирдах албан тушаалтан	-	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	11	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	Давхардсан тоогоор 66			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	

	сургалт		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	-	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	-	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	50	Цалин, шагнал, урамшуулал нь жилийн нийт төсөвт эзлэх хувь 56,7 хувь.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Ажилчдын хоол унааны зардалд өдрийн 10000 төгрөгийг тооцож олгодог. 26,4 сая төгрөг төсөвлөгдсөн.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	2023 оны төсөвт ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах төсөв тусгагдаагүй тул албан хаагчдыг НДЭМН-тай хамтран эрт элрүүлэг шинжилгээнд хамрагдах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар 8 албан хаагч бүрэн хамрагдаж, шинжилгээний үр дүнгийн дагуу эмчилгээ хийлгэж байна.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	2	

7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	300.000	<p>Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Засгийн газрын 2022 оны 488, 491 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын хөдөлмөрийн хөлсийг шинэчлэн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг журмын дагуу олгож байна.</p> <p>2023 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг олгож, ур чадварын нэмэгдлийг холбогдох журмын дагуу тооцон олгодог.</p> <p>Ар гэрийн гачигдал гарсан 1 ажилтанд 300.000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн.</p> <p>Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан, зөрчилгүй ажилласанг үнэлэн 2 албан хаагчийг нэг сарын цалингаар шагнаж урамшуулсан.</p> <p>Албан хаагчдын ажил хөдөлмөрийг үнэлэн БХБЯ-ы “Тэргүүний барилгачин” цол тэмдэгээр – 1, “Жуух бичиг”-ээр 1</p> <p>Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн Тэргүүний ажилтан”</p>
----	--	------	--	---	---------	---

					<p>цол тэмдэгээр – 1 албан хаагчийг өргөн мэдүүлсэн.</p> <p>Архивчдын баярын өдрийг тохиолдуулан Архивын ерөнхий газрын “Хүндэт жуух” бичгээр 1 албан хаагчийг тус тус шагнаж урамшуулсан.</p>
--	--	--	--	--	--

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9 дүгээр хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Эрхэм зорилго, алсын хараа, тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудсанд байршуулсан. Үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын явцыг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
1.2.	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Үйл ажиллагааны чиглэл, бүтэц, холбоо барих, санал хүсэлт, албан хаагчдын мэдээлэл, ажиллах цагийн хуваарийг оруулсан. Захиргааны ажилтан болон Маркетинг, ОНХХ мэргэжилтний нэр, албан тушаал, утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд шинэчлэгдсэн тухай бүрт нь байршуулдаг.	100%
1.3.	эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Газрын даргын хариуцлагын гэрээ, биелэлт, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дотоод хяналт, шалгалтыг гүйцэтгэх комиссын төлөвлөгөө, биелэлт зэргийг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
1.4.	хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж цахим хуудсанд байршуулсан.	100%
1.5.	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	“Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн хүрээнд тус тус хийгдсэн тайлан, биелэлтүүдийг вэб сайтад оруулсан.	100%

1.6.	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	2022 оны 07 сард Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан. Мөн бусад хууль тогтоомжуудыг цаг тухай бүрт нь вэб сайтад оруулдаг.	100%
1.7.	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, холбоо барих утас, цахим хаягийг ил тод мэдээлж, өөрчлөгдсөн тухай бүрт нь шинэчлэдэг.	100%
1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Улирал тус бүрээр тогтмол мэдээллэж ажилладаг.	100%
1.9.	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Барилгын салбарын статистик мэдээллийг Барилга хот байгуулалтын яамнаас шууд авах боломжтой холбоосыг цахим хуудсанд оруулж өгсөн.	100%
1.10.	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах тухай бүртээ байгууллагын вэб хуудас болон орон нутгийн мэдээллийн цахим хуудсуудаар мэдээллэж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Сул орон тоо гарсан тухай бүрт нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хөдөлмөр халамжийн хэлтсээр дамжуулан мэдээллэж, орон нутгийн цахим хуудсуудаар мэдээлэл түгээдэг.	100%
2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Ажилтан сонгон шалгаруулах журам, үе шатыг цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд, анкет, албан тушаалын тодорхойлолт, шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрийн тухай мэдээллийг цахим хуудаснаас авах бүрэн боломжтой.	100%
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	2021 оны 01 сарын 22-ны өдрийн А/02 тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүд, дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд байгууллагын цахим хуудсанд өөрчлөгдсөн цаг тухайд нь оруулсан.	100%
2.4.	хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрүүдийг цахим хуудсанд оруулсан.	100%
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Жил бүр шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээг оруулдаг.	100%
2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Ур чадварын нэмэгдэл олгох журмыг цахим хуудсанд оруулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			

3.1.	өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Цаг тухай бүрт нь оруулдаг.	100%
3.2.	төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг сар бүр оруулдаг. Хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
3.3.	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Жил бүрийн аудитын дүгнэлт болон зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээллэдэг.	100%
3.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төлбөр хураамж, үйлчилгээний хөлс авдаггүй.	100%
3.5.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Тухайн мэдээллүүдийг шилэн дансанд цаг тухай бүрт нь байршуулдаг бөгөөд байгууллагын вэб сайтнаас шилэн данс руу шууд холбогдох боломжийг бүрдүүлсэн.	100%
3.6.	таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		100%
3.7.	цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		100%
3.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		100%
3.9.	шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		Шилэн дансны мэдээллийг тогтмол, бүрэн гүйцэт оруулдаг.
3.10.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүр цахим хуудсаар мэдээллэдэг. Байгууллагын зүгээс зарласан тендэр байхгүй.	100%

	бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан		
3.11.	худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Шилэн данс	100%
3.12.	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Байхгүй.	100%
3.13.	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Бүтээн байгуулалт болон зураг төслийн ажлын явцын талаарх мэдээллийг тухай бүрт нь байршуулдаг. Мөн улс нийслэлийн төсвөөр хэрэгжүүлж буй ажлуудыг нэгтгэн, оны эцэст мэдээлэл оруулдаг.	100%
3.14.	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Байхгүй.	100%
3.15.	хууль тогтоомжид заасан бусад.	Улс нийслэлийн төсвөөр хийгдсэн ажлуудын явц, хэрэгжилт, мөнгөн дүнг тогтмол мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Хамтран ажиллах хүсэлтэй аж ахуйн нэгж, хувь хүмүүст тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулдаг.	100%
4.2.	тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй	Тусгай зөвшөөрөл олгодоггүй.	100%


	болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.		
Хэсгийн дундаж хувь:			100%
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Байхгүй.	100%
5.2.	эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Байхгүй.	100%
5.3.	хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Байхгүй.	100%
5.4.	мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эзэмшиж байгаа 3 газрын гэрээ, гэрчилгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.5.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Байгууллагын нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн үйл ажиллагааны мэдээллүүдийг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
5.6.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн	Удирдах зөвлөл байхгүй.	100%

	этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;		
5.7.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, тайлан дүгнэлтийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээлж ажилладаг.	100%
5.8.	мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.9.	барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Оффисын барилга, худаг, үерийн байгууламж болон авто замын хүлээн авсан акт, дүгнэлтийг цахим хуудсанд оруулсан.	100%
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Парк, Парктай гэрээ байгуулсан ААН-үүд хамтарсан гурвалсан гэрээ байгуулсан. Тус гэрээг байгууллагын цахим хуудсанд ил тод мэдээлж ажилласан.	100%

	зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;		
5.11	нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Байхгүй.	100%
5.12	мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Байгууллагын зардлаар суралцагсдын мэдээллийг цаг тухай бүрт нь оруулдаг.	100%
5.13	хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, гадаад хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, уулзалтын үр дүн, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн ажлууд зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүрт нь ил тод мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



С.БАТЖАРГАЛ

ХЯНАСАН:


АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Н.ПҮРЭВСҮРЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Х.БЯМБАА